

ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ШИРЭЭНИЙ НОМУУД

Товч танилцуулга

Монгол улсын аж ахуйн амьдралтай ямар нэг талаар хэлбоотой иргэд өнөөдөр зах зээлийн эдийн засагтай холбоотой онол, практикийн хамгийн нэр хүндтэй ном, зохиолыг уншиж судлахгүйгээр, ядахдаа товч агуулга, үндсэн санааг мэдэхгүйгээр орчин үеийн зах зээлийн нөхцөлд аж ахуйн аль нэг үйл ажиллагааг алдагдалгүйгээр явуулах нөхцөлгүй юм.

Зах зээлийн эдийн засгийн ухааныг эзэмшин, хөдөлмөрлөх юм бол бодын шийр дөрөв биш, тав зургаа ч болж болдог нь Япон зэрэг байгалийн нөөц баялаг багатай орны хөгжлийн туршлагаас тодорхой харагдаж байна. Иймд манай улс 70 жилийн турш их найрсаг харилцаатай байгаа их хөрш Оросын холбооны улс, зарим түнш оронд сүүлийн жилд гарсан хэдэн номын нэр, тэдгээрийн агуулгын зарим нэн сонирхолтой зүйлийг дор товчхон танилцуулав.

1. Кэмпбелл Р. Маконнелл. Стэнли Л. Брю. Экономикс. Принципы, проблемы и политика. Т. т. I. 2. Москва. Издательство "Республика". 1992.

АНУ-ын Небраск муж улсын эдийн засгийн ухааны профессор К. Маконнелл, Вашингтон муж улсын Номхон далайн Лютеран их сургуулийн эдийн засгийн ухааны профессор С. Брю хоёрын "Эдийн засаг судлал, зарчим, шийдвэрлэх асуудал, улс төрийн бодлого" гэдэг их, дээд сургуулийн сурах бичгийг 1992 онд Москвад оросоор хоёр ботнор /800 хуудастай/ нийтэлжээ. Долоон анги, 41 бүлэгтэй. Хоёрдугаар ботийн шувтэрганд зах зээлийн эдийн засгийн ухагдахуун, нэр томъёоны орос, англи товч тайлбар толь хэвсэргэжээ. Уг толины "А" үсгийн хэсгийг Англи-орос-монгол толь болгон сэтгүүлийнхээ энэ дугаарт нийтлэв. Хойшид 1993 оны дугаарт үргэлж үүлэн нийтэлж дуусгах болно. Энэ зохиолын агуулгын зарим хэсгээс сонирхуулан товчлон орчуулж толилуулъя.

Эдийн засгийн онол. Эдийн засгийн онолын буюу ачлалын зорилт бол баримтуудыг систем болгох, тайлбарлах, нэгтгэн дүгнэх явдал мөн. Эдийн засгийн ачлалын эцсийн үр дүн болох зарчим, онол бол баян баримтыг нэгтгэн холбож, тэдгээрийн хоорондын зохих харилцан холбоосыг тогтсон, эмхэлж, учир утгыг нь гаргаж, тодорхой дүгнэлт хийсэн юм. Баримтгүй онол хоосон байх болно, харин онолгүй баримт утга учиргүй байх болно. Үйлчилгээ, таваарыг үйлдвэрлэх, солилцох, хэрэглэх процесс хүмүүс, журам дэглэмийн бодит авир байдал яваандаа өөрчлөгддөг. Иймд зарчим, онолыг эдийн засгийн орчны өөрчлөлттэй зохицуулан байнга шалгаж байх нь чухал.

Эдийн засгийн зорилтуудыг дор дурдсан 8 зүйлээр тодорхойлж болно. Үүнд:

1. Эдийн засгийн өсөлт. Сайн чанарын үйлчилгээ, таваарыг ихээр үйлдвэрлэх, товчоор хэлбэл хүмүүсийн амьдралын түвшинг нэлээд өндөр байлгах шаардлагатай.

2. Ажлаар бүрэн хангах. Ажиллах чадвартай, ажиллахыг хүссэн хүмүүсийг таарах ажлаар хангах нь чухал.

3. Эдийн засгийн үр ашиг. Үйлдвэрлэлийн байж байгаа

хязгаарлагдмал нөөц баялгийг аль болох багаар зарцуулан аль болох их өгөөжтэй ажиллахыг хүснэ.

4. Үнийн тогтвортой түвшин. Үнийн ерөнхий түвшинг ихээр нэмэгдэх буюу буурах өөрөөр хэлбэл мөнгөний ханш буурах, мөнгөний тоо цөөрөх явдлыг гаргахгүй байх нь чухал.

5. Эдийн засгийн эрх чөлөө. Үйлдвэрлэлийг жолоодон явуулагч хүмүүс, ажилчид, хэрэглэгчид нь эдийн засгийн талаар их хэмжээгээр чөлөөтэй ажиллах ёстой.

6. Орлогыг шударгаар хуваарилах. Улсын иргэдийн нэг хэсэг нь их баян чинээлэг байхад нөгөө нь хэт ядуу байх ёсгүй.

7. Эдийн засгийн хангамж. Архаг өвчтөн, хөдөлмөрийн чадааргүй хүмүүс, өндөр настай зэрэг асрамжийн хүмүүсийн амьдралыг хангах хэрэгтэй.

8. Худалдааны тэнцэл. Өөрсдийн олон улсын худалдаа, санхүүгийн ажиллагааг зохих тэнцэлтэй байлгахыг эрмэлзэх ёстой.

Эдийн засгийн ухааны үндэс. Хоёр суурь баримт нь эдийн засгийн ухааны үндэс болдог. Үүнд: нэгдүгээр баримт нь нийгмийн материаллаг хэрэгцээ хязгааргүй, хангагдашгүй байдаг. Хоёрдох нь эдийн засгийн нөөц баялаг – өөрөөр хэлбэл үйлчилгээ, таваарыг үйлдвэрлэлийн хэрэгсэл хязгаарлагдмал буюу ховор байдаг.

Хэрэгцээ хязгааргүй. Хэрэглэгчид өөрсөддөө ашиг болох үйлчилгээ, таваарыг олж авч, хэрэглэхийг хүсч байдаг. Эдгээр таваар нь шүдний ооноос эхлэн орон сууц, үйлдвэрийн барилга мэтний хязгааргүй олон нэрийн зүйл байдаг. Үйлчилгээ нь үс засах, гутал, машин засварлах мэтний маш олон янз байдаг. Хүмүүс, үйлдвэрийн газар, албан байгууллага зэргийн хэрэгцээ нь шинэ нэр, төрлийн үйлчилгээ, таваар гарах тусам улам л цааш нэмэгдсээр байдаг. Энэ утгаар хэрэгцээ хязгааргүй, хангагдашгүй байна.

Нөөц баялаг хязгаарлагдмал. Эдийн засгийн нөөц баялаг гэж үйлчилгээ, таваарын үйлдвэрлэлд хэрэглэдэг ерөнхийдөө бүх байгаль, хүмүүсийн бүтээсэн зүйлийг хэлнэ. Энэ бүх нөөц баялаг нь үйлдвэр, хөдөө аж ахуйн барилга, байгуулэмж, тээвэр, холбооны янз бүрийн хэрэгсэл, олон янзын хөдөлмөр, газар, янз бүрийн ашигт малтмал зэрэг олон зүйл байна. **Дөрвөн төрлийн нөөц баялаг байна.** Үүнд:

Газар. Газар гэдэгт тариалангийн талбай, бэлчээр, ой, ашигт малтмал, газрын тосны орд, усны нөөц мэтний байгалийн бүх нөөц баялгийг эдийн засагчид хамруулдаг.

Капитал. Капитал буюу хөрөнгө оруулалтын нөөц баялаг нь үйлдвэрлэлийн бүх үйлдвэрлэсэн хэрэгсэл өөрөөр хэлбэл бүх төрлийн багаж, машин, төхөөрөмж, фабрик-завод, агуулах, тээврийн хэрэгсэл, мөн үйлчилгээ, таваарыг үйлдвэрлэх, эцсийн хэрэглэгчдэд хүргэхэд ашигладаг борлуулалтын сүлжээг хамарна. Үйлдвэрлэлийн эдгээр хэрэгслийг үйлдвэрлэх, туримтлуулах процессыг хөрөнгө оруулах гэнэ. Мөнгө чухам өөрөө юу ч үйлдвэрлэж чаддаггүй болохоор эдийн засгийн нөөц баялаг гэж үзэж болохгүй. Бодит капитал болох багаж, машин бусад үйлдвэрлэх төхөөрөмж бол эдийн засгийн нөөц баялаг мөн. Мөнгө буюу санхүүгийн капитал бол эдийн засгийн нөөц баялаг биш.

Хөдөлмөр. Хөдөлмөр бол үйлчилгээ, таваарын үйлдвэрлэлд хэрэглэдэг биеийн ба оюуны бүх авьяасыг тэмдэглэх өргөн нэр томъёо юм. Бизнес өвсгөөг үүнд оруулсангүй. Ингэхлээр худалдагч, машинист, багш, мэргэжлийн тамирчин-, цөмийн физикийн ажил бол хөдөлмөр гэдэг нэг ухагдахуунд багтана.

Бизнес өвсгөө. энэст нь хүний онцгой нөөц баялаг болох бизнес өвсгөө гэдэг нэр томъёог хоорондоо уялдаатай дөрвөн функцээр ярих болно.

1. Бизнесмен / бизнес эрхлэгч хүн / нь үйлчилгээ, таваар үйлдвэрлэх нэгдмэл процесст газар, капитал, хөдөлмөр гэх нөөц баялгийг нэгтгэн оруулах санаачилгыг өөрөө эрхлэн явуулахдаа үйлдвэрлэлийн хөдөлгөгч хүчин ч болдог, мөн ашиг өгөх энэ процессыг хэрэгжүүлэхэд бусад

нөөц баялгийг хамтатгаж байдаг жууцлагч ч болдог.

2. Бизнесмен уг газрын үйл ажиллагааны бодлогыг тодорхойлдог үндсэн шийдвэрийг гаргах хэцүү зорилтыг өөртөө хүлээдэг.

3. Бизнесмен бол наймааны үндсэн дээр шинэ бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн шинэ технологи тэр ч байтугай бизнес зохион байгуулах шинэ хэлбэрийг бий болгохыг эрмэлздэг шинийг бүтээгч мөн.

4. Бизнесмен бол азаа туршдаг хүн юм. Энэ нь түүний дээр дурдсан гурван функцээс урган гарна. Бизнесмен бол капиталист систем дотор заавал ашигтай байх нь баталгаагүй. Тэр хамаг цаг, хүч, авьяас, чармайлтаа гаргаад, ашиг олж болно, эсхүл алдагдал хүлээн, эцэстээ дампуурч болно.

Америкийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

1. Үйлдвэрлэлийн хэмжээ, орлого. 1988 онд АНУ-д 4862 тэрбум /миллиард/ долларын үйлчилгээ, тавгаар үйлдвэрлэсэн нь бусад аль ч орныхоос их байна. Нэг хүнд ногдох бүтээгдэхүүний хэмжээ 17840 доллар байхад Японд 12840 доллар, Англид 8870 доллар, Мексикт 1860 доллар, Этиопид 120 доллар байна. Гэвч холбооны засгийн газрын шалгуураар АНУ-ын бүх оршин суугчийн 13% гаруй нь ядуу амьдарч байна.

2. Үнийн түвшин. Түүхэнд үнийн түвшин дээшилж ч байсан, буурч ч байна. 1988 он гэхэд 1967 оныг бодвол үнийн түвшин бараг 3, 3 дахин дээшилсэн.

3. Ажил эрхлэлт, ажилгүйдэл. АНУ-д дэлхийн хоёрдугаар дайнаас хойш ажил эрхлэгчдийн тоо 1947 онд 57 сая байснаа 1988 онд 115 сая болжээ. Сүүлийн 10 жилд АНУ-д ажилгүйдлийн жилийн дундаж түвшин 7, 3% байна.

4. Үйлдвэрийн газар. АНУ-д байгаа 17600000 хувийн фирмийн барагцаалбал 82% нь корпорац /монополь нэгдэл/ биш жижиг үйлдвэр, үйлчилгээний газар юм. Үлдэх 18% нь хувийн үйлдвэрийн газрын худалдааны нийт хэмжээний 50% орчмыг эзэлдэг корпорац юм. Америкийн хамгийн том корпорац болох "Женерал моторз" корпорацийг улс гэж үзвэл түүний бүтээгдэхүүний хэмжээ нь барагцаалбал дэлхийн 22 буюу 24 улсаас бусад бүх улсын бүтээгдэхүүний хэмжээнээс давж байна. 1987 онд 61622 фирм дампуурсан, гэхдээ мөн онд 685600 шинэ компани байгуулагдсан.

5. Засгийн газар. Холбооны, муж улсуудын, мөн ерон нутгийн захиргаанд үндэсний бүтээгдэхүүний 20% орчим нь ноогдоно. Тус орны зургаан ажилтны нэг нь улсын албанд ажилладаг.

6. Гадаад худалдаа. АНУ 1987 онд 251 тэрбум долларын үйлчилгээ, таваарыг экспортлож, 410 тэрбум долларынхыг импортолсон нь үндэсний бүтээгдэхүүний 11% нь экспорт, 13% нь импорт болжээ. АНУ-ын худалдааны хамгийн том түнш нь Япон биш, Канад эм. П.

Самуэльсон. Экономика Т. т 1, 2. Москва, МГП "Алгон". ВНИИСИ 1992.

Америкийн эдийн засагч, Нобелийн шагналт П. Самуэльсоны "Эдийн засгийн ухаан" ном нь 41 бүлгийг хамарсан 6 ангитай. Үүнд:

1-р анги Эдийн засгийн үндсэн айнууд /категориуд/, үндэсний орлого /1-11-р бүлэг/

2-р анги. Үндэсний орлогын ба түүний хэлбэлзлийн түвшинг тодорхойлох нь /12-19-р бүлэг/

3-р анги. Үндэсний бүтээгдэхүүн, түүний бүрэлдэхүүн хэсгүүд, үнийн бүрдэлт /20-25-р бүлэг/

4-р анги. Орлогын хуваарилалт: үйлдвэрлэлийн хүчин зүйлүүдэд үнэ тогтоох нь /26-30-р бүлэг/

5-р анги. Олон улсын худалдаа, санхүү /31-34-р бүлэг/

6-р анги. Орчин үеийн эдийн засгийн асуудлууд /35-41-р бүлэг/

П. Самуэльсон эдийн засгийн онолын асуудлыг ерийн хүний ой, ухаанд орохоор энгийн үгээр тайлбарлан бичсэн байна

П. Самуэльсон "Олны нэг нь мөн", "Эрүүл ухаан, дэмий юм",

"Үгсийн харгислал", "Онол, практик", Бүхэл, хэсэг: "нотолгоог буруу хийх нь", "Аливаа эдийн засгийн хэлбэршлийн гол асуудлууд" мэтийн агуулга ихтэй боловч оновчтой гарчгийн доор энгийн үгээр ойлгомжтой тайлбарлажээ. Зөвхөн эдгээр гарчигаас үзэхэд эдийн засаг /аж ахуй/ гэдэг бол нэг талаар онол, практик, эрүүл ухаан, овсгоо шаардсан, нөгөө талаар нийгмийн бүх амьдрал, түүний тухай- ниймийн олон салбар ухаангай салшгүй холбоотой маш нарийн төвөгтэй зүйл болох нь эргэлзээгүй байна. Эдгээр гарчгийн агуулгатай товч танилцуулбал:

Олны нэг нь мөн. Эдийн засгийн онол буюу ердийн нэрлэдгээр улс төрийн эдийн засгийн ухаан бол нийгэм судлал, улс төийн ухаан, сэтгэл судлал, хүн судлал мэтийн нийгмийн шинжлэх ухааны судлах зүйлтэй холбоотой байдаг. Жишээлбэл: Ядуурсан Энэтхэгт үнээг онгон, ариун амьтан гэж үздэг. Ингээд олон сая үнээ идэш эрэн гудамжаар тэнэж явдгийг Энэтхэгт ирсэн нэг эдийн засагч ажиглажээ. Гэтэл хүний мөн чанарыг огт ойлгодоггүй гэнэн эдийн засагч бол тэдгээр үнээг уурагт тэжээлийн нэг эх үүсвэр гэж үзэх болно. Харин үндэсний заншил, сэтгэл судлалын холбогдлыг сайн ойлгодог алсын хараатай эдийн засагч бол Энэтхэгийн хөгжлийг задлан шинжлэхдээ нийгэм судлалын нэг хүчин зүйлийг харгалзан үзэж, ниймэрхүү байдал нь улс төрийн бүтэц, мөн улс төрийн бодлогод нөлөөлдөг бүлэг хүмүүст нөлөөлөх болно гэдгийг заавал анхаарч үзнэ.

Эрүүл ухаан, дэмий юм. Эдийн засгийн бодлогоор маргалдах нь олонтаа байдаг. Үнэ, цалин, хүү, хувьцаа, хонжворт зээллэг, банк, зээл, татвар, зардал бол маш нарийн ертөнц юм. Урт хугацаанд нарийн судлаагүй ямар ч хүн хими мэтийн нарийн ухааны учрыг олохгүй. Өнгөцхөн мэдлэг бас осолтой байдаг. Ямар нэг асуудлыг нарийн судлаад үзэх юм бол ерийн эрүүл ухааны үүднээс зөв юм шиг байсан зүйл дэмий юм болж болно.

Үгсийн харгислал. Нийгмийн шинжлэх ухаанд "үгсийн харгислал" явуулахаас онц болгоомжилдог. Ертөнц маш нарийн төвөгтэй болохоор судалгаагүй, тодорхой биш үгс хэлж самууруулах хэрэггүй юм. Хүний хэлсэн үг анхарагдахгүй байдаггүй. Эдийн засгийн хөгжлийн төрийн хөтөлбөрийг сайшаагч хүн түүнийг "ухалаг төлөвлөлт" гэнэ, гэтэл уг хөтөлбөрийг талархдаггүй хүн түүнийг "тоталитар хүнд суртлын журамлалт" гэж нэрлэх болно. Ямар хүн нэгдэхий нь эсэргүүцэж, хоёрд хы нь зөвшөөрч болох вэ?

Онол, практик. Эдийн засгийн ертөнц, маш нарийн юм. Эдийн засгийн холбогдолтой холбогдолгүй олон мэдээ, баримтыг эмхлэн, хялбарчилж, хийсвэрлэж, онолын үүднээс дүгнэхгүйгээр хэн ч учры нь олохгүй. Онол нь практик дээр шалгагдана. Практикийг онолоор дүгнэнэ.

Бүхэл, хэсэг: "нотолгоог буруу хийх" нь. Эдийн засгийн онолыг судалж байгаа хүн бол юмыг олонтоо санагддаг /харагддаг/ байдлаар нь авч үзэж болохгүй гэдэг энэ чухал дүрмийг юуны өмнө эзэмших ёстой. Үүнийг дорхи жишээнүүдээр үзүүлбэл:

1. Бүх фермер шургуу хөдөлмөрлөөд цаг агаар тааламжтай байхад үзэгдээгүй их ургац авах юм бол фермерүүдийн орлогын нийт дүн нь багасч болно, багасах нь магадтай.

2. Ажил олох гэсэн нэг хүн ажил олох их авьяастай байгаад эсхүл бага цалин авахыг зөвшөөрөөд энэ асуудлаа шийдвэрлэж чадсан байхад ажил олох гэсэн бусад бүх хүн нйм замаар уг асуудлыг шийдвэрлэж болохгүй.

3. Нэг салбарын бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэнээс тэр салбартай холбоотой хүмүүс хожиж болно, гэхдээ худалдан авч, худалддаг бүх юмны үнэ нэгэн зэрэг нэмэгдсэнээс хэн ч хожихгүй.

4. Бусад орсон импортлож байгаа бараанд оногдуулах гаалийг хорьгдуулахыг зөвшөөрөхгүй байхад АНУ зөвшөөрөөд ашиг олж болно.

5. Нэг фирм ямар нэг ажил эрхлэхтэй холбогдсон бүх зардлыг уг ажлыг эрхлэн нөхөж болохгүй байхад түүнийг хийгээд ашиг олж болох

юм. 6. Тус тус хүмүүс эдийн засгийн бууралтын үед өөрсдийн хадгаламжийг нэмэгдүүлэхийг эрмэлзэх нь тухайн нийгэм дэх хадгаламжийн нийт дүнг бууруулж болно.

7. Нэг хүн буюу фирмийн хувьд сайн юм гэж үзэгдэх зүйл нь яваандаа нийт үндэстэн буюу улсын хувьд т-нэг зүйл болж болно. Энэ дурдсан нотолгоо бүр нь зөв гэдгийг онцлон тэмдэглэе. Гэхдээ эдгээр нь өнгөцхөн харахад тачин байна. Иймэрхүү хачин юмыг энэ номд шийдэх болно.

Аливаа эдийн засгийн хэлбэршлийн гол асуудлууд. Аливаа нийгэм бол бүрэн хамтын коммунист улс уу, Өмнөд тэнгисийн арлуудын оршин суугч аймаг уу, капиталист аж үйлдвэрийн орон уу, робинзоны гэр бүлийнхэн үү, эсхүл ганц Робинзон Крузо юу, тэр ч байтугай ерийн үүр зөгий байна уу, алин ч байсан дор дурдах эдийн засгийн хоорондоо холбоотой үндсэн гурван асуудлыг аль нэг замаар шийдвэрлэх ёстой. Үүнд:

1. Юуг үйлдвэрлэх ёстой вэ, өөрөөр хэлбэл бие биенээ үгүйсгэсэн үйлчилгээ, тавааруудын чухам алины нь, хэдий хэмжээгээр үйлдвэрлэх ёстой вэ?

2. Таваарыг яаж үйлдвэрлэх ёстой вэ, өөрөөр хэлбэл ямар нэгц, ямар технологи ашиглах, хэн үйлдвэрлэх ёстой вэ?

3. Үйлдвэрлэсэн тавааруудыг хэнд зориулах вэ, өөрөөр хэлбэл эдгээр үйлчилгээ, таваарыг хэн эзэмшиж, ашиг олох ёстой вэ?, Өөр үгээр хэлбэл үндэсний нийт бүтээгдэхүүнийг янз бүрийн хүмүүс, гэр бүлийн хооронд хэрхэн хуваарилах ёстой вэ?

Эдгээр гурван асуудал бол бүх аж ахуйн хувьд үндсэн, нийтлэг юм. Харин эдийн засгийн янз бүрийн систем янз янзаар шийдвэрлэхийг оролддог юм.

П. Самуэльсон "Арьсны ба хүйсний ялгааны эдийн засаг" гэх 37-р бүлэгт АНУ-д арьсны өнгө, эрэгтэй, эмэгтэй хүнийг ялгаварлан гадуурхах нь амьдрал дээр байдгийн улмаас хүмүүсийн цалин амьдралын түвшин, тэгш биш байдгийн эдийн засгийн үзүүлэлтийг тодорхой дурджээ. Үүнд: АНУ-ын хар арьстай нэгэн 9 хүний 1 нь маш бага орлого олж ядуу амьдарч байдаг. Эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдтэй адил боловсрол, авьяастай байгаад яг ижил ажил хийсэн мөртлөө эрэгтэйчүүдийн цалингийн 70%-ийг авдаг.

Америкийн эдийн засагчдын эдгээр бүтээл нь дээр дурдсан шиг сонин санаа, дүгнэлт, баримт, диаграмтай орчин үеийн зах зээлийн эдийн засгийн ухааны бүтээл юм.